

Багц цагийн сургалт эрхлэх зөвшөөрөл шинээр хүсэх болон эрх сунгах байгууллагууд "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах журам"-д заасны дагуу дараах материалыг бүрдүүлэн ЭМХТ-ийн бичиг хэрэгт цаасаар эсхүл [admin@hdc.gov.mn](mailto:admin@hdc.gov.mn) хаягт цахимаар ирүүлнэ үү.

## **I. Шинээр зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материал**

### **1. Хүсэлт:**

- Сургалт эрхлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг (байгууллагын тамга, тэмдэг, эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулсан байх).
- Сургалтын чиглэлийг тодорхой заасан байх.

### **2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ:**

- Шуудангаар илгээх бол нотариатаар баталгаажуулсан хуулбар.
- Байгууллагын төлөөлөл хүргэх тохиолдолд эх хувийг хуулбарын хамт авчрах.

### **3. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл:**

- Сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар.

### **4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө:**

- Эрх хүсэж буй сургалтын чиглэлээр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө.

### **5. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх журам:**

- Байгууллагын эрх бүхий албан тушаалтан баталсан байх.

### **6. Байгууллагын танилцуулга:**

- Сургалтын чиглэлд нийцсэн сургалтын орчны талаарх мэдээлэл (танхим, техник хэрэгсэл, лаборатори, хэвлэх, хувилах төхөөрөмж, интернет бүхий компьютерийн танхим зэрэг).
- Гэрэл зураг болон холбогдох баримт бичиг хавсаргах.

### **7. Сургалтын нэгжийн бүтэц, хүний нөөц:**

- Батлагдсан орон тоо бүхий сургалтын нэгж эсхүл төгсөлтийн дараах сургалтын асуудал хариуцсан орон тооны ажилтантайг нотлох баримт.
- Батлагдсан бүтэц, дүрэм эсвэл орон тоо, албан тушаалын жагсаалт, хөдөлмөрийн гэрээ гэх мэт.

### **8. Багшлах бүрэлдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга:**

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүн

## **II. Эрх сунгах байгууллагын бүрдүүлэх материал**

**1. Хүсэлт:**

- Эрх сунгах тухай албан бичиг (байгууллагын албан тамга, тэмдэг, эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулсан байх).

**2. Сургалтын тайлан:**

- Өмнөх хугацаанд явуулсан сургалтын дэлгэрэнгүй тайлан.
- Хамрагдсан оролцогчдын тоо, үнэлгээ, үр дүнгийн мэдээлэл.

**3. Сургалтын шинэчилсэн хөтөлбөр, төлөвлөгөө:**

- Хэрэв хөтөлбөрт өөрчлөлт орсон бол шинэчилсэн хувилбар.

**4. Багш нарын шинэчилсэн мэдээлэл:**

- Өмнөх багш нарын удирдсан сургалтын мэдээлэл.
- Шинээр нэмэгдсэн багш нарын мэргэжлийн диплом, гэрчилгээний хуулбар, танилцуулга.

**5. Материаллаг баазын шинэчлэл:**

- Сургалтын орчин, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн мэдээлэл.

**Тайлбар:**

- Бүх материалуудыг бүрэн, үнэн зөв бүрдүүлэх шаардлагатай.
- Шинэ чиглэлээр эрх хүсэх тохиолдолд шинээр зөвшөөрөл хүсэхтэй адил материалыг бүрдүүлнэ.

Хянасан:

Б.Отгончимэг

Боловсруулсан:

Б.Батнаран